

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ СЭДЭВТ УУЛЗАЛТ, ӨДӨРЛӨГ “GOVSEC-2017”-с ГАРСАН ЗӨВЛӨМЖ

“Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдал” сэдэвт уулзалт өдөрлөгийг төрийн захиргааны байгууллагууд, нийслэлийн харьяа төрийн байгууллагууд, төрийн өмчит компаниуд, төрийн өмчит үйлдвэрийн газрын бодлого төлөвлөлт, мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан удирдах ажилтан, албан хаагчдын хүрээнд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний Дата төв УТҮГазраас Төрийн мэдээлэл холбооны газар, Цахим аюулгүй байдлын мэдээллийн удирдлагын төвтэй хамтран 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Хууль сахиулахын их сургууль дээр зохион байгууллаа. Тус уулзалт, өдөрлөгөөр хэлэлцэгдсэн асуудлуудын хүрээнд дараах зөвлөмжийг гаргалаа.

Нэг. Мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд

- Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийг төр, байгууллага, иргэний эрх үүргийн хэмжээнд оновчтой, олон улсын жишигт нийцсэн зөв хувилбараар боловсруулан, батлуулах;
- Мэдээллийн аюулгүй байдлын батлагдсан үндэсний стандартуудыг нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэх;
- Төрийн байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлын үндэсний стандартуудыг нутагшуулах;
- Төрийн захиргааны байгууллагад 2 жил тутам мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлэх;
- Төрийн бүх шатны байгууллагууд дотоод мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журамтай болох, журмын хэрэгжилтийг хангуулах ажилд байгууллага бүр анхаарах;
- Төрийн байгууллагуудын мэдээллийг ангилах, мэдээллийн ангиллаар хамгаалалтын түвшин тогтоох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

Хоёр. Хүний нөөцийг чадавхижуулах ажлын хүрээнд

- Төрийн онц чухал дэд бүтэц бүхий байгууллагууд мэдээллийн аюулгүй байдлын нэгжтэй болох, бусад бүх шатны төрийн байгууллагууд мэдээллийн аюулгүй байдал хариуцсан албан хаагчтай байх;
- Төрд мэдээллийн технологийн чиглэлээр ажиллаж буй албан хаагчдыг мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтнээр мэргэшүүлэн сургах;

- Төрд мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын асуудал хариуцсан албан хаагчдыг тогтвортой ажиллуулах боломжийг бүрдүүлэх;
- Төрийн бүх шатны албан хаагчдад цахим болон цаасан суурьтай мэдээллийг хадгалах, хамгаалах мэдлэг ойлголт, ухамсар соёлыг төлөвшүүлэх сургалт арга хэмжээг тогтмол зохион байгуулах;
- Төрийн мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ эрх бүхий албан хаагчдыг мэргэшүүлэх, сертификатжуулах;
- Төрд мэдээллийн технологийн чиглэлээр ажиллаж буй албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ, дүрэмтэй болох;

Гурав. Програм хангамж, техник хангамж, сүлжээний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд

- Төрийн байгууллагуудын мэдээллийн систем, програм хангамж, тоног төхөөрөмжийг лицензжүүлэх;
- Төрийн байгууллага, онц чухал дэд бүтэц бүхий байгууллагад ашиглагдах програм хангамж, мэдээллийн систем, техник, тоног төхөөрөмжийг шалган баталгаажуулдаг лаборатори байгуулах;
- Төрийн байгууллагын төсөвт мэдээллийн аюулгүй байдлыг хангахад зориулж зарцуулах төсвийг жил бүр суулгах;
- Төрийн байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлын тоног төхөөрөмж суурилуулах;

Дөрөв. Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны ажлын хүрээнд

- Мэдээлэл алдах эрсдэлээс сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, сайн туршлага солилцох;
- Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын зөвлөлийг байгуулах;
- Төрийн байгууллагууд салбарынхаа хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах олон нийтийн мэдлэг ойлголтыг сайжруулах арга хэмжээг жилд хоёроос доошгүй зохион байгуулах;

Уулзалт, өдөрлөгт оролцогчид

2017 оны 4 дүгээр сарын 28

Улаанбаатар хот